

Түүх 6 : Саа өвчтэй хүн

Библийн эшлэл
[Лук 5:246]

Саа өвчтөнд – Би чамд хэлье. Бос, дэвсгэрээ аваад гэртээ харь гэв.

Есүс өвчтэй хүмүүсийг эдгээж байна гэх мэдээ Израиль даяар тархсан бөгөөд үүний талаар мэдэхгүй хүн нэг ч байхгүй болов. Тиймээс маш олон хүмүүс Есүсийн явсан газар болгонд цугларцгааж байлаа.

Нэгэн өдөр Есүс Капернаум гэх тосгонд ирэхээр болов.

Тэр тосгонд алхаж чаддаггүй төдийгүй хоолоо өөрөө идэж чаддаггүй нэгэн саа өвчтэй хүн байжээ.

Найзууд нь саа өвчтэй найзыгаа аваад Есүс рүү аваачихаар болов.

Найзууд нь бат бөх саваа мод болон даавуу бэлдээд дамнуурга хийв.

Найздаа тусалж байгаа найзууд нь бүх хүчээ гаргаж Есүсийн байгаа газарт хүрч очив.

Гэтэл тухайн гэрт Есүстэй уулзах гэсэн хүмүүсээр дүүрсэн байсан тул гэр лүү орох зай байхгүй байв.

Тэд шувуу шиг далавчтай бол нисчихмээр л байв.

Найзууд нь Есүсийн байгаа гэрийн дээвэр дээр гарч дээврийг нь нүхэлж эхлэв.

Гэрт байсан хүмүүс бүгд цочирдон дээвэр лүү харав.

Найзууд нь дамнуургад олс уяад саа өвчтэй хүнийг яг Есүсийн өмнө буулгав.

Ингэж саа өвчтэй найз нь Есүстэй ойртож чадсан юм.

Есүс, найзуудын итгэлийг хараад маш ихээр сайшаав.

Тэгээд Есүс саа өвчтэй нэгэнд ингэж айлдав. “Хүү минь, нүгэл чинь уучлагдлаа.

Би чамд хэлж байна босоод дэвсгэрээ аваад гэрлүүгээ яв.” гэв.

Есүсийг ярьж дуусмагц хөдөлж ч чадахгүй байсан хүн гэнэт босож,

Есүст талархлаа илэрхийлэв.

Саа өвчтэй байсан тэрээр Бурханыг алдаршуулангаа дамнуургаа аван гэртээ харив.

Тэнд байсан бүх хүмүүс болсон явдлыг хараад Бурханыг магтан алдаршуулав.



	ТАЙЛБАР	З	Б
1	Египетийн бүх хүмүүс “Есүс өвчтэй хүмүүсийг эдгээж байна” гэх сургийг сонссон.		
2	Есүс Капернаумд ирэв.		
3	Капернаумд саа өвчтэй хүн амьдарч байсан.		
4	Саа өвчтэй хүний найзууд нь түүнд зориулж тэргэнцэр хийсэн.		
5	Есүс саа өвчтэй хүний болон түүний найзуудийн итгэлийг харсан тул саа өвчтэй хүнийг эдгээсэн.		

- Дараах библийн эшлэлийг уншаад цээжлээрэй. (Лук 5:246)

Би чамд хэлье. Бос, дэвсгэрээ аваад гэртээ харь гэв.

